

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2021 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр

Дугаар А-226

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1, Банкны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Банкийг тогтворжуулах төлөвлөгөө боловсруулах, батлах хэрэгжүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.2.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар (Н.Ариунбат), Хяналт шалгалтын газар (Ц.Нарандай)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН